

22

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Сүхбаатрын талбай 3 хаягт байрлах компанийн төв байранд зайнаас Zoom webinar ашиглан 2023 оны 6 дүгээр сарын 30-ны өдрийн 09:00 цагт 75,38 хувийн ирцтэйгээр зохион байгуулагдав.

Хурлын дарга:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
С.Тулга

Хурлын тооллогын комисс:

Дарга:

Бүртгэлийн албаны ахлах
мэргэжилтэн Д.Нямдорж

Гишүүд:

Арилжааны систем зохицуулагч
Б.Батмөнх

Судалгаа хариуцсан мэргэжилтэн
Б.Шинэцэцэг

Эрсдэлийн мэргэжилтэн Д.Өлзийбат

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, батлах;
2. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэж батлах;
3. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.

СОНССОН нь:

Тооллогын комиссын дарга Д.Нямдорж: “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд 264,179,323 ширхэг хувьцаа эзэмшдэг 66 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 350,463,539 энгийн хувьцааны 75.38 хувь болж байх тул Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийг үндэслэн нийт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын ирцийг баталгаажуулан хуралд оролцогчид болон хурлын даргад мэдэгдэв.

23

Хурлын дарга С.Тулга: Хурлыг нээж үг хэлэв. Ээлжит бус хурлын дэгийг танилцуулж, хурлын дэгтэй холбоотойгоор саналтай хувьцаа эзэмшигч байгаагүй буюу хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид дэмжсэн тул дэгийг баталсныг мэдэгдэв.

Тооллогын комиссын дарга Д.Нямдорж: Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаарх дэлгэрэнгүй зааврын танилцуулав.

Хурлын дарга С.Тулга: Танилцуулга хийсэн Тооллогын комисст баярлалаа. Ингээд хөтөлбөрийнхөө дагуу эхний хэлэлцэх асуудал руугаа оръё. “Компанийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах” асуудал байгаа, танилцуулгыг Гүйцэтгэх захирал Х.Алтай хийнэ.

1. Компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, батлах

Гүйцэтгэх захирал Х.Алтай: “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг танилцуулав.

Хурлын дарга С.Тулга: Танилцуулга хийсэн Х.Алтай захиралд баярлалаа. Танилцуулгатай холбогдолтой асуулт, хариулт хурлын дэгийн дагуу явагдана. Асуулт асуух, хариулах хугацаа 1 минут байна гэсэн дэгээ баримтлаад явъя.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 2 хувьцаа эзэмшигч асуулт асууж, хариулт авав. Мөн 1 хувьцаа эзэмшигчийн зүгээс санал хэлж, уг санал нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуультай зөрчилдөх тул хүлээж авах боломжгүй талаар хурлын дарга мэдэгдэв.

Хурлын дарга С.Тулга: Асуулт асуусан хувьцаа эзэмшигчдэд нэмж тодруулах зүйл байгаа юу?. Ингээд дараагийн асуудал руугаа оръё. Хоёр дахь асуудал буюу өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар төслийг нь танилцуулсан “Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ийг өнөөдөр батална. /Танилцуулгыг Тулга дарга хийв./

2. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэж, батлах

Хурлын дарга С.Тулга: Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөл, саналын товъёог танилцуулав.

Хурлын дарга С.Тулга: Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг хэлэлцэж, батлахтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдээс асуулт байгаа эсэхийг тодруулав.

Асуулт, хариулт, санал: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асуугаагүй болно.

Хурлын дарга С.Тулга: Хөтөлбөрийн дагуу Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох асуудал байгаа. Үүнтэй холбоотойгоор Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй анкетийг нэгтэгсэн байдлаар танилцуулах гэж байна. *Танилцуулгын ТУЗ-ийн дарга С.Тулга танилцуулав/*

3. ,4. *Хяналтын зөвлөлийн гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох*

Хурлын дарга С.Тулга: Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчидтэй холбоотой асуултаа эхлүүлье.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчийн зүгээс асуулт асуугаагүй болно.

Хурлын дарга С.Тулга: За. Асуулт байхгүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчидтэй холбоотой хувьцаа эзэмшигчдээс асуулт байна уу?. За Нямдорж хувьцаа эзэмшигчээс гараа өргөсөн байна. Микрофоныг нээж өгье.

Асуулт, хариулт, санал: Хэлэлцэж буй асуудалтай холбоотойгоор 2 хувьцаа эзэмшигч асуулт асууж, 1 хувьцаа эзэмшигч санал гаргав. Асуултад ТУЗ-ийн дарга С.Тулга хариулав.

Хурлын дарга С.Тулга: Н.Энхбаяр хувьцаа эзэмшигчээс Хяналтын зөвлөлд хуульч хүн оруулмаар байна гэсэн санал ирүүлсэн байна. Одоогийн хяналтын зөвлөлд нэр дэвшээд байгаа Ц.Мөнхзул нэр дэвшигч маань хуульч, өмгөөлөгч хүн байгаа. За ингээд өөр асуулттай гишүүд байхгүй бол санал хураалтаа эхлүүе. Хувьцаа эзэмшигчид та бүхэн д тооллогын комиссоос танилцуулсан санал хураах зааврын дагуу санал хураалтдаа идэвхитэй оролцоорой. Санал хураалтын хугацаа хөтөлбөрийн дагуу 20 минут үргэлжилнэ. Санал хураалтын үр дүнг 20 минутын дараа тооллогын комисс танилцуулна.

Тооллогын комиссын дарга Д.Нямдорж: Санал хураалтын дүн, Тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Хурлын дарга С.Тулга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолуудыг танилцуулж, хаалтын үг хэлснээр хурлыг хаав.

Санал хураалтын дүнгийн тухай

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж, батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 96.74% буюу 254,851,645 ширхэг хувьцаатай 34 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 97.34% зөвшөөрсөн, 2.66% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

- Зөвшөөрсөн 248,064,016 ширхэг хувьцаа буюу 97.34 хувь,
- Татгалзсан 6,787,530 ширхэг хувьцаа буюу 2.66 хувь,
- Түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь,

2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 96.47% буюу 254,851,645 ширхэг хувьцаатай 34 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 97.35% зөвшөөрсөн, 2.65% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

- Зөвшөөрсөн 248,106,139 ширхэг хувьцаа буюу 97.35 хувь,
- Татгалзсан 6,745,407 ширхэг хувьцаа буюу 2.65 хувь,
- Түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь,

3. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 96.47% буюу 254,851,645 ширхэг хувьцаатай 34 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөнөөс нэр дэвшигчид дараах саналыг авсан байна.

№	Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Б.Туяарах	248,139,611	6,710,511	1,424
2	Б.Батбаяр	250,773,508	3,077,038	1,001,000
3	Ц.Мөнхзул	246,105,542	8,746,004	0

4. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 97.34% буюу 254,851,645 ширхэг хувьцаатай 34 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөнөөс нэр дэвшигчид дараах саналыг авсан байна.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын тоо
Ердийн гишүүд		
1	Ж.Цогтбаяр	417,906,539
2	Д.Тогтохбаяр	487,730,703
3	М.Бат	1,954,750
4	Т.Ганбаатар	416,874,685

5	С.Баянцогт	515,339,722
6	Ж.Бямбасүрэн	417,852,684

Дээрх нэр дэвшигдээс хамгийн өндөр санал авсан 5 нэр дэвшигчид нь Ж.Цогтбаяр, Д.Тогтохбаяр, Т.Ганбаатар, С.Баянцогт, Ж.Бямбасүрэн нар байна.

5. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 97.34% буюу 254,851,645 ширхэг хувьцаатай 34 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөнөөс нэр дэвшигчид дараах саналыг авсан байна.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын тоо
Хараат бус гишүүд		
1	Р.Мөнхтөр	25,472,547
2	М.Банзрагч	1,212,064
3	Н.Улаанхүү	412,250
4	Н.Отгончимэг	8,907,966

Дээрх нэр дэвшигдээс хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчид нь Р.Мөнхтөр, Н.Отгончимэг, М.Банзрагч, Н.Улаанхүү нар байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хавсралт ёсоор батлав;
 - 1.1. Энэ тогтоолоор дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусгасан “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийг хавсралтаар баталгаажуулав.
 - 1.2. Компанийн оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагад өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгов.
 - 1.3. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгов.
 - 1.4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгав.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар батлав;

- 24
- 2.1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар батлав.
 - 2.2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.
 3. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгов.
 - 3.1. Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 2 жил хүртэл хугацаатайгаар сонгосугай.
 - 3.2. Хяналтын зөвлөлийн гишүүнээр:
 1. Б.Туяарах
 2. Б.Батбаяр
 3. Ц.Мөнхзул
 - 3.3. Хяналтын зөвлөлийн гишүүний урамшууллын хэмжээг хуралдсан тооноос хамааруулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай.
 - 3.4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналтын зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Тэмүүжин/-д үүрэг болгосугай.
 4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 3 жилийн хугацаатайгаар сонгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:


- 1) Ж.Цогтбаяр
- 2) Д.Тогтохбаяр
- 3) С.Баянцогт
- 4) Т.Ганбаатар
- 5) Ж.Бямбасүрэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1) Р.Мөнхтөр
- 2) М.Банзрагч
- 3) Н.Улаанхүү
- 4) Н.Отгончимэг

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.ТУЛГА

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Г.Тэмүүжин

